



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/18/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024

Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор:

П.Амаржаргал

Утас: 99890393

Цахим хаяг: amaraa_802002@yahoo.com

Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	9
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар	11
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.. Error! Bookmark not defined.	
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	11
2.11.	Шилэн дансны мэдээлэл	12
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл: Error! Bookmark not defined.	
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Менежментийн захидал	Error! Bookmark not defined.
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГА Ж.МӨНХСОЁЛ ТАНАА 7

2019.03.25 № 2/167

танай _____-ны № _____-г

Г _____ 7

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянхонгор сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон

D:\Amaraa\amaraa\2019\BHR negtgel\Баянхонгор сум ТЭЗ гэрчилгээ.docx

7519321

удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Баянхонгор сумын Засаг дарга нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\Аmараа\amараа\2019\BHR negtgel\Баянхонгор сум ТЕЗ гэрчилгээ.docx

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Сумын Засаг дарга Мөнхсоёл-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Баянхонгор сумын Засаг дарга 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн зах

ирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019-03-06-наас 2019-03-12–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019-03-25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-ын П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2019-02-25-ны өдрийн дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор сумын Засаг дарга талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор сумын Засаг дарга нь “Өндөр мэдлэг, ур чадвартай зарчимч мэргэшсэн, төрийн албан хаагчдыг үр дүнтэй, тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж, сумын удирдлагад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, сумын нийгэм эдийн засгийн хөгжлийн бодит нөхцөлд шинжилгээ хийж, иргэддээ үйлчлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор сумын Засаг дарга үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн олон талт цогц үйлчилгээ хүргэн, Төрийн удирдлагыг нээлттэй, ил тод, шуурхай байлгах
- Эрх зүйн сургалт, сурталчилгааг тогтмолжуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх.
- Төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадвар, туршлагыг дээшлүүлэн хүний нөөцийн хөгжлийг хангах зэрэг болно.

Баянхонгор сумын Засаг дарга удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 30 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 1 байгууллага аудитын хийлгээгүй 29 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Баянхонгор сумын Засаг дарга эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	24	2	0	1	1
2	ТБӨӨААН	0	0	0	2	0
	Дүн	24	2		3	1

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баянхонгор сумын Засаг дарга мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор сумын Засаг дарга санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор сумын Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Э-тайлан” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын Засаг дарга дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Баянхонгор сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийжээ. Аудитаар СЗДТГазар 2018 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 4,890,000 төгрөгийн гудамж хариуцсан идэвхтнүүдийн урамшууллыг байршуулаагүй, Номгон ахлах сургууль 2018 оны 06 дугаар сарын 12,121,936 төгрөгийн үр дүнгийн урамшууллын зардлыг байршуулаагүй, 15 дугаар цэцэрлэг 2018 оны 4 дүгээр сарын 23-ний өдрийн 8,385,000 төгрөгийн дрожны үнийн зардлыг байршуулаагүй, 2 дугаар цэцэрлэг нь 2018 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 3,777,300 төгрөгийн санхүүжилтыг байршуулаагүй, Номундалай сургууль 2018.06.08 №71 - багш ажилчдад 2 дугаар улиралын урамшуулал олгох тухай, 2018.06.08 №72 - мэргэжлийн багш, сургалтын менежерүүдэд нэмэгдэл олгох тухай, 2 дугаар цэцэрлэг 2018.05.29 №А/23 – хагас жилийн эд хөрөнгийн тооллого хийх тухай, 4 дүгээр цэцэрлэг 2018.05.29 №А/08 – хагас жилийн эд хөрөнгийн тооллого хийх тухай, 5 дугаар цэцэрлэг 2018.05.29 №1/1/17 – хагас жилийн эд хөрөнгийн тооллого хийх тухай, 2018.05.29 №1/1/18 – эд хөрөнгө орлогодож авах тухай, 9 дүгээр цэцэрлэг 2018.05.29 №1/1/18 – өмчийн эд хөрөнгийн тооллого хийх тухай, 2018.06.08 – багш ажилтанд үр дүнгийн урамшуулал олгох тухай /pdf файлаар байршуулаагүй/ зэрэг зөрчил дутагдал гарсан байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор сумын Засаг дарга бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Баянхонгор сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 17907,7 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 179,0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Баянхонгор сумын Засаг дарга болон төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 95770,4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 60734,5 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан байна.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад илэрсэн асуудлыг үзүүлэв. Үүнд:

2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Асуудал 1.1: Баянхонгор сумын Номгон ахлах сургууль нь утасны төлбөр 672,9 мянган төгрөгийг ажилчдаас суутгаагүй атлаа цалингийн зардлаас шилжүүлсэн, тайлант онд Ё.Цолмонд 2018 оны 1,2,3 дугаар саруудад тус тус 25000 төгрөгийг цалингийн цэстээр гарт олгох цалин дээр нэмж олгосон байна, Тайлант онд 5 ажилтнаас 1730449 төгрөгийн цалингийн урьдчилгааг суутган тооцоогүй, авлагаар бүртгээгүй байна.

Асуудал 1.2: Баянхонгор сумын 4-р цэцэрлэг нь Нягтлан бодогч Г.Баатар 2018.02.08-аас ажилд орсон байхад цалинг бүтэн тооцож, 37062 төгрөгийн цалинг илүү олгосон. 2018 оны 05 дугаар сард цалингийн цэстээр олговол зохих цалингаас 30605 төгрөгийг илүү олгосон. Хувь хүний орлогын албан татварын тооцоолол зөрүүтэй, 2-р улиралд олгосон 1928001 төгрөгийн үр дүнгийн урамшууллаас 171592 төгрөгийн татвар суутган тооцоогүй байна.

Асуудал 1.3: Баянхонгор сумын Эрдэм ахлах сургууль нь Тайлант онд цалингаас суутгасан НДШ нь 91298009 төгрөг байхад Татварын хэлтэс болон Нийгмийн даатгалын хэлтэст мэдээлсэн НДШ-ийн дүн 3014,3 мянган төгрөгөөр зөрүүтэй буюу 94312351 төгрөг байна. Энэ нь 6 сард багш нарын ээлжийн амралтын цалин олгохдоо НДШ-ийн дээд хязгаарлалтыг буруу тооцож нийт дүнгээс нь НДШ-ийг суутгасан атлаа НДХ-т цалинг 6.7.8 саруудад хувааж мэдээлсэнтэй холбоотой байна, Оны эхэнд татварын 97975,5 төгрөгийн авлагатай байсныг барагдуулсан байна. Тайлант онд ажиллагсдаас 65276616 төгрөгийг суутган 64839604 төгрөгийг татварт шилжүүлж, татварын мэдээгээр 2087194,6 төгрөгийн авлагатай гарсан байхад санхүүгийн тайланд 424047 төгрөгийг авлагаар тусгаж, 1663147,6 төгрөгийн авлагыг тайланд тусгаагүй байна. Сургуулийн гал тогоо, тоног төхөөрөмжийг түрээслэгч "Тосуйн гол" ХХК-тай

байгуулсан гэрээг мөрдөж ажиллаагүй, түрээсийн төлбөрийн 233,383 төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.

Асуудал 1.4: Баянхонгор сумын 9-р цэцэрлэг нь Тайлант хугацаанд олгосон цалингийн зардлын гүйлгээг цалингийн цэстээс давтан тооцоолж, баталгаажуулахад үйлчлэгчээр ажиллаж байсан Ц.Оюунбилэгт 214.7 мянган төгрөгийн цалин, ня-бо Н.Уламбаярт тушаал шийдвэргүй 211.4 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл илүү олгосон, мөн нягтлан бодогч өөрийнхөө НДШ-ыг 166.5 мянган төгрөгөөр илүү мэдээлж 38.3 мянган төгрөгийн НДШ-ийг байгууллагаас төлсөн, цэвэр бохир усны зардлыг гэрээний дүнгээс илүү анхан шатны баримтгүй 229.7 мянган төгрөгийн шилжүүлсэн зөрчлүүд илэрсэн.

Асуудал 1.5: Баянхонгор сумын СХС-аас зээл авсан иргэдийн авлага, өглөгийг судалгаа болон мөнгөн хөрөнгийн журналаас тулган шалгахад 32.918.3 мянган төгрөгийн зээлийн төлөлтийн хугацаа хэтэрсэн байхад төлүүлэх арга хэмжээ аваагүй байна.

Шийдэл: Дээрх зөрчилтэй асуудлуудад төлбөрийн акт тогтоосон байна.

Асуудал 2: Баянхонгор сумын Номгон ахлах сургууль нь Тайлант хугацаанд цалингийн санг нийгмийн даатгалын хэлтэст мэдээлэхдээ 8080275 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн байна.

Асуудал 3: Баянхонгор сумын 4-р цэцэрлэг нь Тайлант хугацаанд оны эцэст хийсэн тооллогын бүртгэлтэй тодруулгын тайлангийн дүнтэй тулгахад машин тоног төхөөрөмж, бусад хангамжийн материалын тооллогын бүртгэл дүнтэй тохирохгүй байна. Энэ нь тооллогын бүртгэлийн нийт дүнг буруу гаргасан, нягтлан бодогч тооллогын бүртгэлд үндэслэн тооцоо бодсон акт үйлдээгүйтэй холбоотой байна, Өмнөх оны аудитаар зардлыг тооцооны дансаар дамжуулж байх зөвлөмж өгсөн байхад хэрэгжүүлэлгүй, тайлант онд зөрчлийг дахин давтаж, 3438349 төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардлаар тайлагнасан, Завсарын аудитаар бараа материалын эхний үлдэгдэлд хасах тэмдэгтэй хөрөнгө бүртгэлтэй байсныг залруулах зөвлөмж өгсөн байхад хэрэгжүүлээгүй, бараа материалын дэлгэрэнгүй тайлангаар авч үзэхэд 288,3 мянган төгрөгийн бараа материал хасах тэмдэгтэй бүртгэгдсэн байна, Завсарын аудитаар бараа материалыг бөөн дүнгээр бичсэн зөрчилд өмнөх ажилтнуудаас тодруулж, оны эцсийн тайланд материалыг хөрөнгө тус бүрээр задалж бүртгэх зөвлөмж өгсөн байхад хэрэгжүүлээгүй байна, Тайлант онд олгосон цалинг Нийгмийн даатгалын хэлтэст 79213 төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн, 1-р сард Ч.Баярсайханд олгосон цалингийн 106685, 2-р сард Н.Сосорбарамд олгосон 56346 төгрөгийн цалинг НДХ-т мэдээлээгүй, гарт олгох дүнг цалингийн цэстэд оруулж олгосон. Даатгуулагчийн цалинг тухайн сард зөв мэдээлээгүйгээс даатгуулагчаас суутгасан НДШ-ийг 16122 төгрөгөөр зөрүүтэй мэдээлж, түүнийг байгууллагаас төлсөн, 2018 оны 12 дугаар сард кассаар 236000 төгрөгийг олгосон атлаа кассын тайлан гаргаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Асуудал 4: Баянхонгор сумын Номун далай ахлах сургууль нь Малчны ажлын хөлсөнд 1521.0 мянган төгрөг төсвөөс төлсөн, Баянхонгор сумын Номун далай ахлах сургууль нь Үдийн цайны зардлаас 13,8 сая төгрөгийг цалингийн зардалд шилжүүлэн зарцуулсан.

Асуудал 5: Баянхонгор сумын 11-р цэцэрлэг нь Няравын тайланг бүрэн гаргаагүй анхан шатны баримтаар БМ-ын журналд шууд бичилт хийсэн зөрчил илэрсэн.

Асуудал 6: Баянхонгор сумын Эрдэм ахлах сургууль нь түрээсийн гэрээг байгуулахдаа аймгийн ИТХ-аас баталсан тогтоолоор тогтоосон тарифийг мөрдөөгүй, холбогдох

хүмүүсээр албажуулаагүй, зарим бараа материалыг зарлагадсан байхад үлдэгдлээр бүртгэлтэй байгаа, зарим бараа материалыг программд материалын бөөн дүнгээр бүртгэсэн.

Асуудал 7: Баянхонгор сумын 1-р цэцэрлэг нь Төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаагүй тооцоо үндэслэлгүй түлшний модыг их хэмжээгээр бэлдсэн зөрчлүүд илэрсэн.

Шийдэл: Дээрх зөрчлүүдэд зөвлөмж өгсөн.

Асуудал 3.1: Баянхонгор сумын 15-р цэцэрлэг нь мөнгөн хөрөнгийн журналын орлого, зарлага мөнгөн гүйлгээний дүнгээс зөрүүтэй, ажил гүйцэтгэх гэрээ, ачаа тээвэрлүүлснийг нотлох баримтгүйгээр тээврийн хөлс төлсөн зөрчил илэрсэн.

Шийдэл: Албан шаардлага өгсөн.

Асуудал 4.1: Баянхонгор сумын Номгон, Эрдэм ахлах сургуулиуд, Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын алба, Баянхонгор сумын 4, 9, 14,15, 11-р цэцэрлэгүүд, Баянхонгор Төхижилт үйлчилгээ ОНТҮГазарт нийт 60734,5 мянган төгрөгийн бүртгэл, тайлагналтай холбоотой зөрчил илэрсэн.

Шийдэл: Санхүүгийн тайлангийн аудитын үед холбогдох тайлан тус бүрд нь залруулга хийсэн.

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчилтэйд тооцох асуудал илрээгүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор сумын Засаг даргын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 15641342,6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 15533931,7 мянган төгрөг буюу 96.2 хувьтай байгаа нь 107410,9 төгрөг хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг авч үзвэл орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 1087,9 мянган төгрөг ба гүйцэтгэлээр 1232,1 мянган төгрөгийн орлого төвлөрч 144,2 мянган төгрөг буюу 113,2 хувиар давуулан биелүүлсэн байна. Үүнд ИОТХуудсаар орсон орлого 223,0 мянга, Улсын тэмдэгтийн хураамж 17,5 мянга, Бууны татвар 5,9 мянга, Хүү, торгуулийн орлого 86,2 мянган төгрөг, нохойны албан татвар 0,96 мянган төгрөг, Харин ҮХЭХ борлуулсны татвар 102,8 мянга, бусад татвар 424,5 мянга, ус рашаан ашигласны төлбөр 58,8 мянга, хог хаягдлын хураамж 312,4 мянган төгрөгөөр төвлөрсөн ба тус орлогуудыг төсөвт оруулахаар төлөвлөөгүй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 17 төрлийн 118 мэдээллээс 99 мэдээллийг хугацаанд нь, 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 22 гүйлгээг хугацаанд нь тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар байхгүй хувьтай байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор сумын Засаг дарга 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)			
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт
					Дүн

Баянхонгор сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

		өгөхөөс татгалзсан				
1	ТШЗ	26	1	0	0	27
2	ТБОӨААН	2	0	0	0	2
	Дүн	28	1		0	29

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

2 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Тайлант он	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,356,799,940.95	3,464,048,786.92
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	380,387,367.25	439,755,503.78
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	380,387,367.25	439,755,503.78
3121	Төгрөг	380,387,367.25	439,755,503.78
31211	Төрийн сангийн харилцах	380,387,367.25	439,755,503.78
33	АВЛАГА	733,348,283.05	836,475,843.66
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,035,189.08	9,139,146.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	700,000.00
335	Бусад авлага	15,888,796.97	29,266,055.66
3351	Байгууллагаас авах авлага	13,152,296.97	13,307,537.86
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,736,500.00	15,958,517.80
336	Зээлийн авлага	716,424,297.00	797,370,642.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	716,424,297.00	797,370,642.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл		797,370,642.00
34	УРЬДЧИЛГАА	-	9,000,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	9,000,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	9,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,032,358,521.03	1,233,401,027.86
351	Түүхий эд материал	253,784,012.45	299,515,561.77
35110	Тусгай зориулалттай материал	251,813,515.14	297,429,029.65
35130	Эм боох материал	1,970,497.31	2,086,532.12
354	Хангамжийн материал	768,010,508.58	925,136,466.09
35410	Бичиг хэргийн материал	45,817,620.06	50,754,280.06
35420	Аж ахуйн материал	194,770,779.64	226,340,933.06
35430	Сэлбэг хэрэгсэл	5,772,465.60	7,056,465.60
35440	Түлш, шатах тослох материал	9,503,860.58	17,094,809.78
35450	Барилгын засварын материал	16,445,105.00	20,687,645.00
35460	Хүнсний материал	24,924,253.43	27,203,943.84
35470	Бусад хангамжийн материал	470,776,424.27	575,998,388.75
35600	Мал амьтад	10,564,000.00	8,749,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	210,705,769.62	945,416,411.62
36100	Барааны нөөц	-	761,999,050.00
36600	Бусад нөөц	210,705,769.62	183,417,361.62
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	19,534,019,672.67	27,149,991,819.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	19,534,019,672.67	27,149,991,819.24
392	Биет хөрөнгө	19,523,604,339.44	22,937,791,402.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	34,079,724,897.60	21,877,275,015.26
39202	Хуримтлагдсан элэгдэл	(16,181,146,446.15)	(381,052,849.26)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	150,910,762.00	240,210,762.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(91,196,687.16)	(114,437,767.73)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,270,980,879.40	2,379,557,864.83
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,647,375,754.82)	(1,864,246,451.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,302,975,222.32	1,425,567,978.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	(793,143,776.37)	(903,207,866.28)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	194,732.56	194,732.56
39214	Бусад үндсэн хөрөнгө	381,404,179.60	265,378,937.57
39215	Хуримтлагдсан элэгдэл	(160,369,989.33)	(106,087,335.48)

Баянхонгор сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39217	Ном	210,646,319.79	118,638,382.31
393	Биет бус хөрөнгө	10,415,333.23	4,212,200,416.30
39301	Програм хангамж	29,435,578.00	87,472,578.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(24,504,091.93)	(26,078,161.70)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,079,466.00	4,150,806,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	21,890,819,613.62	30,614,040,606.16
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,561,785.18	6,410,801.30
